



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарын хөгжлийн агентлаг

# ЖИЛИЙН ТАЙЛАН 2017

ШВЕЙЦАРЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ МОНГОЛД






## **Жилийн тайлан 2017**



### **Швейцарын хөгжлийн агентлаг**

#### **Швейцарын ЭСЯ-ны Хамтын ажиллагааны газар**

Скай Плаза бизнес төв  
Элчингийн гудамж 9, 1-р хороо  
Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар  
Монгол Улс

Ш/х 37  
Улаанбаатар 14210  
Монгол улс

 976 11 331422  
 976 11 331420  
 ulaanbaatar@eda.admin.ch

 [www.eda.admin.ch/mongolia](http://www.eda.admin.ch/mongolia)  
 Swiss Cooperation in Mongolia

#### **Гэрэл зураг & Эх бэлтгэл**

Швейцарын ЭСЯ-ны Хамтын  
ажиллагааны газар  
Интерпресс ХХК

Гэрэл зураг @ ШХА

#### **Хэвлэлт**

Интерпресс ХХК

© SDC 2018



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарын хөгжлийн агентлаг

# ЖИЛИЙН ТАЙЛАН 2017

ШВЕЙЦАРЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ МОНГОЛД

## Агуулга

Удиртгал	4
ШХА-ийн Монгол дахь хөтөлбөрийн онцлох үр дүн:	6
■ Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал	7
■ Мэргэжлийн боловсрол, сургалт	11
■ Төрийн захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал, иргэдийн оролцоо	15
■ Тогтвортой бичил уурхай төсөл	19
2018 оны хэтийн төлөв:	21

# Удиртгал

2017 он Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хувьд онцлог үйл явдлаар дүүрэн жил байлаа. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль, Засгийн газар огцорсон, Монгол Улсын эдийн засгийг тогтворжуулан сэргээх зорилгоор ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг гурван жилээр сунгасан зэргийг дурьдаж болох юм.

Ардчилсан намаас нэр дэвшигч Х.Баттулга эрх баригч Монгол Ардын Нам (МАН)-аас нэр дэвшсэн өрсөлдөгч М.Энхболдыг дахин сонгуульд ялснаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдов. Шинэ сонгогдсон Ерөнхийлөгч болон МАН олонхын суудал эзэлж байгаа УИХ, Засгийн газрын бодлогын ялгаа зөрүүгээс болж бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц удаашрах магадлалтай ч ноцтой нөлөө үзүүлэхээргүй байна. Ерөнхийлөгчийн сонгуульд ялагдал хүлээсэн МАН дотроо хариуцлага тооцож, намаа шинэчлэх эрмэлзлээр өнгөрсөн есдүгээр сард хариуцлагагүй, авлигад холбогдсон гэх үндэслэлээр Засгийн газраа огцруулсан. 2016 оны УИХ-ын сонгуульд МАН үнэмлэхүй ялалт байгуулахад улс төрийн тогтвортой байдал хангагдах нь гэсэн хүлээлт харамсалтай нь биеллээ олсонгүй. Хэдийгээр улс төрийн хүрээнд дээр дурдсан өөрчлөлтүүд гарсан ч ШХА-ийн тус улстай байгуулсан Хамтын ажиллагааны стратеги Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны Мөрийн хөтөлбөрт нийцэж байгаа бөгөөд ШХА-ийн хэрэгжүүлж байгаа ихэнх төсөл Монгол Улсын төр засгийн байгууллагуудад танигдсан, тэдний дэмжлэгийг хүлээсэн хэвээр байгаа юм. ШХА шинэ Засгийн газартай бодлогын яриа хэлэлцээгээ үргэлжлүүлнэ.

ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсанаар Монгол Улс өр,

төлбөрөө эргэн төлөх чадваргүй гэж зарлахаас сэргийлж, эдийн засгийн тогтвортой байдлыг сэргээх бүтцийн өөрчлөлт хийх боломж нээгдсэн юм. Эдийн засаг сэргэж буй эхний шинж тэмдэг ажиглагдаж байгаа нь ОУВС-ийн хөтөлбөрөөс гадна нүүрс болон зэсийн үнэ өссөнтэй холбоотой гэж тайлбарлажээ. Гэхдээ улс төрийн тогтворгүй байдал, уул уурхайн салбараас хэт хамаарсан байдал, их хэмжээний өр, төлбөр зэрэг асуудлаас үүдэн ойрын ирээдүйд эдийн засаг бүрэн сэргэх боломж хомс байна. Нийгмийн салбарын төсөв хязгаарлагдмал байгаа тул үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад хүндрэл учруулж байна. Эдийн засгийн нөхцөл байдлын улмаас ядуурал (2016: 29.6%; 2014: 21.6%) нэмэгдсэн нь ШХА-ийн хөтөлбөр, төслүүдийн хувьд ядуурал, жендэрийн асуудалд илүү анхаарах шаардлагатайг бататгаж байна. Эдийн засгийг төрөлжүүлэх, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд ШХА-ийн оруулж буй хувь нэмэр ялангуяа хөдөөгийн хүн амын хувьд чухал ач холбогдолтой хэвээр байна.

Хотжилт хурдацтай явж байгаа нь ядуурлын шинэ сорилтуудыг бий болгож байна. Гэр хороололд үйлчилгээний хүртээмж хангалтгүй, өвлийн улиралд агаарын бохирдол нийгмийн эрүүл мэндийн томоохон хямрал дагуулж, олон нийтийг бухимдлыг төрүүлж, жагсаал цуглаан хийхэд хүргэж байна. Засгийн газар энэ чиглэлээр олон арга хэмжээ авч буй ч үр дүн төдийлөн гарахгүй байна. ШХА-ийн гурван тэргүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа хэд хэдэн хөтөлбөрт хотын захын хорооллын ядуурлын асуудлыг тусгасан. “Хэтийн төлөв 2020” төслийн хүрээнд аливаа үйл ажиллагааг эхлээд хот суурин газруудад туршин, амжилттай хэрэгжиж байгааг нь цаашид хамтын ажиллагааны 2018-2020 оны шинэ стратегийн дор бүрэн хэмжээний хөтөлбөр болгох юм.




### **Монгол дахь Швейцарын хөгжлийн агентлагийн тухайд**

Швейцарын хөгжлийн агентлаг (ШХА) нь Швейцар улсын Засгийн газрын олон улсын хамтын ажиллагааны байгууллага юм. ШХА нь 2004 оноос эхлэн Монгол улсын зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн дараах олон салбарын шинэтгэл, хөгжилд дэмжлэг туслалцаа үзүүлж буй томоохон хандивлагчийн нэг юм.

2018 онд ШХА Монгол дахь хамтын ажиллагааны 2018-2021 оны стратегиа танилцуулсан. ШХА-ын стратегийн зорилго бол **иргэн бүрт хүртээмжтэй, эрх тэгш, ногоон, хөгжингүй нийгмийг байгуулах Монгол улсын иргэд, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах** явдал юм.

Энэхүү зорилгоо хэрэгжүүлэхийн тулд сүүлийн арав гаруй жил Монголд хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа үр дүн, тэргүүн туршлагуудыг нэгтгэн зангидаж дараах гурван үндсэн чиглэлд үргэлжлүүлэн чиглүүлнэ. Үүнд:

- Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал;
- Мэргэжлийн боловсрол, сургалт;
- Засаглал.



# ШХА-ийн Монгол дахь хөтөлбөрийн онцлох үр дүн:



## Хөдөө аж ахуй ба хүнсний аюулгүй байдлын үндсэн чиглэлээр:

Бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ) болон Бэлчээр ашиглалтын гэрээ (БАГ)-ний аргачлалыг илүү өргөн хүрээнд, албан ёсны болгох замаар 18 аймагт бэлчээрийн тогтвортой менежментийг нэвтрүүлэх ажлыг эхэллээ. Дотоодын боловсруулах үйлдвэрүүдтэй малчдын хоршоодыг зуучлан холбож, илүү чанартай түүхий эд нийлүүлснээр үнээ өсгөж чадсан тул бэлчээр ашиглагчдын хэсгийн малчдын орлого нэмэгджээ. Мөн хүнсний ногооны салбар ч бэхжсээр байна.



## Мэргэжлийн боловсрол, сургалтын үндсэн чиглэлээр:

ШХА-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдийн нөлөөллийн үр дүнд залуучуудын асуудлыг үндэсний бодлогод илүү өргөн тусгаж чадлаа. Сургалтын хөтөлбөр боловсруулах, мэргэжлийн чадварыг үнэлэх, үйлдвэрлэлийн дадлагажуулагч багш бэлтгэх, үйлдвэрийн дадлага, ажлын байр санал болгох, нийгмийн түншлэлийг зохицуулах хүрээг тодорхойлох зэрэг мэргэжлийн боловсрол, сургалтын бүхий л үйл явцад хувийн хэвшлийн оролцоо нэмэгдлээ.



## Засаглалын үндсэн чиглэлээр:

Орон нутгийн засаглалын тогтолцоонд бодит үр дүн гарч, нийгмийн эгэх хариуцлагын механизмуудыг албан ёсоор хэрэгжүүлж эхлээд байна. Чадавч бэхжүүлэх талаарх өргөн хүрээний хүчин чармайлтын үр дүнд төрийн үйлчилгээ, орон нутгийн засаг захиргаа, иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагаа сайжирч байна. Засаглалын асуудалд ШХА-ийн тэргүүлэх ач холбогдол өгсөн хэвээр байна. Цаашид хөтөлбөрүүдийн үр дүнг бататгах шаардлагатай бөгөөд хотын захын хорооллуудад чиглэсэн тодорхой салбарын засаглалыг бэхжүүлэх чиглэлээр ажиллана.



## Тогтвортой бичил уурхай төсөл:

ШХА-ийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын бичил уурхайн салбар илүү хүлээн зөвшөөрөгдөж, 2017 онд бичил уурхайтай холбоотой асуудлуудыг бодлогын чухал баримт бичгүүдэд тусгажээ. Бичил уурхайчдын хөдөлмөр эрхлэлтийг албан ёсны болгох, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг нөхөн сэргээх чиглэлээр илүү анхаарах болсон.





Хөдөө аж ахуй, хүнсний  
аюулгүй байдал

# Хөтөлбөрийн онцлох үр дүн

## Бэлчээрийн тогтвортой менежмент

“Ногоон алт”, “Малын эрүүл мэнд” төслүүдийн үр дүнг бусад аймгуудад нэвтрүүлэх, бэлчээрийн тогтвортой менежментийг институцийн хувьд бэхжүүлэх зорилго бүхий нэгдсэн төслийг 2017 онд ШХА-аас хэрэгжүүлж эхэллээ. Ногоон алт - Малын эрүүл мэндийн нэгдсэн (“Ногоон алт”) төсөл нь малчдын байгууллагуудыг бэхжүүлж, хоршоод, боловсруулах үйлдвэрийн хоорондын хамтын ажиллагаа болон малын эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах чиглэлээр ажлаа үргэлжлүүлж байна. Бэлчээрийн тогтвортой менежментийн дадал хэвшлийг дэмжиж, зах зээлтэй холбож өгснөөр малчдын амьжиргаа сайжирсан. Бэлчээрийн доройтлыг бууруулах


нь нэн тэргүүний шийдвэрлэвэл зохих асуудал гэдэг талаар олон нийтийн мэдлэг, ойлголт нэмэгдэж байна.

Бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ) болон Бэлчээр ашиглалтын гэрээ (БАГ)-ний аргачлалыг Монгол улсын нийт 21 аймгийн 18-д нь нэвтрүүлж эхэлснээр 1380 БАХ-т хамрагдсан 42,000 малчин өрх (нийт малчин өрхийн дөрөвний нэг) бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлж байна. БАХ/БАГ-ний аргачлалыг үндэсний хэмжээнд яам, агентлагууд хариуцан хэрэгжүүлж, цаашдын тогтвортой байдлыг хангаж байна. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын үндэсний хэмжээний мэдээллийн санд бэлчээр ашиглалтын гэрээг бүртгэх болсон нь уг тогтолцоо албан ёсны болж байгаа бас нэг хэлбэр юм. 2016 онд 700 орчим бэлчээр ашиглалтын гэрээ байгуулагдсан бол 2017 онд уг тоо 740 болж өсчээ.

Монголын Бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо (МБАНХ) идэвхтэй ажиллаж, БАХ/БАГ-ний аргачлалыг хэрэгжүүлэх, цаашид өргөн нэвтрүүлэхийн тулд гуравдагч талын санхүүжилтийг бие даан босгох болсон. Баян-Өлгий аймагт БАХ-ийн тогтолцоо бие даан ажиллаж, бүтэн цагаар ажиллаж буй 25 ажилтны хоёроос бусад нь байгууллагаасаа цалинжиж байна. БАХ/БАГ-ний тогтолцоог хэрэгжүүлснээр бэлчээр ашиглалтын зөрчил маргаан эрс буурсан, малчдын ашиг сонирхлыг төлөөлдөг гишүүнчлэлд тулгуурласан байгууллагадаа сэтгэл хангалуун байгаагаар малчид илэрхийлж байна.

МБАНХ нь гишүүдийнхээ чадавхыг дээшлүүлэхэд хөрөнгө оруулж, олон төрлийн сургалтуудыг зохион байгуулсан. Тус холбоо нь бусад мэргэжлийн холбоодтой хамтран түүхий эд бэлтгэлийн чанарыг дээшлүүлэх сургалтад зургаан аймгийн 33 сумын 4000 орчим малчдыг (41.7% нь эмэгтэйчүүд) хамруулжээ. Махны нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх туршилтын 15 сумыг сонгосон ба 11 сумын 1399 малчид (44% нь эмэгтэйчүүд) малын эрүүл мэндийн сургалтанд хамрагдсан.

УИХ арванхоёрдугаар сард Малын эрүүл мэндийн тухай шинэ хуулийг баталсан нь





малын эрүүл мэндийн стандартыг олон улсын стандарттай нийцүүлэх, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх урьдчилсан нөхцлийг хангах чухал алхам боллоо. Шинэ хууль хэрэгжсэнээр хөдөө аж ахуйн салбарыг бэхжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэхэд хувь нэмэр оруулна. Шинэ хууль нь мал эмнэлгийн үйлчилгээний бүтэц, тогтолцоог төгөлдөржүүлэх замаар малын эрүүл мэндийг сайжруулах, оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгох, босоо удирдлагын тогтолцоо бүрдүүлэх, малын өвчинд шинжлэх ухааны үндэслэлтэй хяналт тавих



Сарлагийн хөөврийг самнаснаар малчдын орлого нэмэгдэх боллоо. © ШХА

шийдвэр гаргах, малын бүртгэл мэдээллийн системийг баталгаажуулж, хэрэглэгчдэд аюулгүй малын бүтээгдэхүүн нийлүүлж нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн.

Ногоон алт төсөл нь үйл ажиллагаандаа жендэрийн тэгш байдлыг хангахад анхаарч ирлээ. БАХ болон Сумын бэлчээр ашиглагчдын холбоог (СБАХ) удирдаж буй эмэгтэйчүүдийн тоо 188 (18 хувь) байгаа хэдий ч зорилтот түвшин болох 40 хувьд хүргэхээр ажиллах хэрэгтэй. Эмэгтэйчүүдээс бүрдсэн анхны хоршоог Баянхонгор аймгийн Богд суманд 60 гишүүнтэй байгуулжээ. Удирдлага, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдсэн нь эмэгтэйчүүд 139 БАХ, 29 СБАХ-г ахалж, Аймгийн Бэлчээр ашиглагчдын холбооны гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаагаас харагдаж байна. Энэ нь 2016 онтой харьцуулахад 60-аар нэмэгджээ.

Өвөлжилтийн бэлтгэлийг сайжруулах малчдын санаачлагын үр дүнд малын тэжээлийн үйлдвэрлэл нэмэгджээ. 2017 онд СБАХ, хоршоод 400 тонн, малчид хувиараа 100 тонн тэжээл бэлтгэсэн нь 2016 оныхоос 20 тонноор илүү байна.

### **Хүнсний ногооны хүртээмжтэй үйлдвэрлэл, маркетинг**

ШХА нь Монгол улсын газар тариалангийн салбарт амжилттай хэрэгжүүлсэн хөтөлбөрөөрөө олон нийтэд танигдсан бөгөөд ялангуяа төмсний дотоодын үйлдвэрлэл хэрэгцээгээ бүрэн хангах чадвартай болсон нь Монгол төмс хөтөлбөрийн үр дүн юм. Монгол төмс хөтөлбөрийн амжилтад үндэслэн ШХА нь Хүнсний ногооны хүртээмжтэй ба тогтвортой үйлдвэрлэл, маркетингийг сайжруулах “Монгол ногоо” төслийг хэрэгжүүлж, хүнсний ногооны салбарыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. 2017 онд дотоодын үр үржүүлэгчид хүнсний ногооны гол төрөл болох шар лууван, улаан манжин, шар манжингийн дотоодын үрийн хэрэгцээг 100 хувь ханган нийлүүлээ.

Улаанбаатар хотын Налайх, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газраас тус төслийн гэр хороолол дахь хүнсний ногооны тариалалт, хэрэглээг нэмэгдүүлэх бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааг дэмжин гурван нэмэлт худгийг санхүүжүүлсэн. Мөн Улаанбаатар хотод есөн загвар гудамжинд 152 ядуу өрх хүлэмж, үр, багаж хэрэгслийн дэмжлэг авав. Мөн худагтай болсноор ундны болон усалгааны усаа авахад хялбар болжээ. Нэг өрх дунджаар 212 кг хүнсний ногоо үйлдвэрлэж, өрхийн хэрэгцээнээс илүү гарсан бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулж эхэлжээ. Загвар гудамжны өрхүүд төрөл бүрийн хүнсний ногоогоор өрхийн хэрэгцээгээ хангагдаад зогсохгүй хөршүүдтэйгээ

сайн хөршийн харилцаатай болж байгаадаа сэтгэл хангалуун байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд Таримал үр, сортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, тус төсөл хүнсний ногооны бүрэлдэхүүнд нь ажиллаж байна.

Монгол ногоо төслийн дэмжлэгтэйгээр мэргэшсэн эрдэм шинжилгээний байгууллагууд 17 хүнсний ногооны 65 гаруй төрлийг туршиж тариалжээ. Мөн уг төслөөр ногоочдод түгээсэн хүлэмжийн талбайн хэмжээ 7000 м<sup>2</sup> давж байна. Хувийн 280, хамтын эзэмшлийн 700 тонн бүхий хадгалах хүчин чадалтай агуулахууд нь тариаланчдыг хүнсний ногоогоо тохиромжтой нөхцөлд удаан хугацаагаар хадгалж, илүү үнээр зах зээлд нийлүүлэх боломжийг олгов. Хоршоодын найман гишүүн анхны худалдааны гэрээгээ Дельта Холдинг ХХК-тай байгуулж, 900 тонн байцаа ханган нийлүүлэхээр тохирчээ. Гурван суманд Тариаланчдын нэвтрүүлэх төв буюу экстейншин төвийг байгуулахад нь дэмжлэг үзүүлснээр орон нутгийн тариаланчдын ур чадварыг дээшлүүлж, техникийн боломжоор хангаж, зах зээлийн мэдээллийг цаг алдалгүй хүргэж байна. 2017 онд нэмэлт хоёр төвийг дэмжиж, тариаланчдад хөдөө аж ахуйн ноу-хау, орчин үеийн технологи, зөвлөх үйлчилгээ үзүүлж байна.

# АМЖИЛТЫН ТҮҮХЭЭС

## ЭГЭЛ МАЛЧНААС БАГИЙН ЗАСАГ ДАРГА БОЛСОН НЬ



Д. Дүгэрсүрэн нутгийн малчдынхаа итгэлийг хүлээж багийн засаг даргаар сонгогдов. © ШХА

“Анх сумынхаа иргэдийн төлөөлөгчдийн хуралд сонгогдохдоо би өөрийгөө хангалттай хэмжээнд боловсрол эзэмшээгүй хэмээн голж байлаа. Харин найз нөхөд, хамт олон маань намайг дэмжиж, итгэл хүлээлгэж байсан нь надад урам өгсөн юм” гэж Д. Дүгэрсүрэн Завхан аймгийн Цагаанхайрхан сумын багийн засаг даргаар томилогдсоныхоо дараах сэтгэгдлээ хуваалцсан юм.

Ногоон алт төслийн ололт амжилт яахын аргагүй Д.Дүгэрсүрэн шиг бүтээлч, хөдөлмөрч манлайлагчидтай холбоотой. Төслийн зүгээс орон нутагт тулгамдаж буй бэрхшээлийг шийдвэрлэх гарцыг олох, холбогдох арга хэмжээ авахад нь иргэдэд дэмжлэг үзүүлдэг бол харин төслийн үр дүнг цаашид тогтвортой авч явдаг бүлэг нь орон нутгийн иргэд болон тэднийг манлайлагчид байдаг. Малчдын амьжиргааг залгуулагч үндэс суурь нь болох бэлчээрийг тогтвортой ашиглах, зохион байгуулах үйл хэрэг сайн дураараа нутгийн иргэд, хамт олноо манлайлан удирдах манлайлагчдаас ихээхэн хамаардаг. Тэдгээр манлайлагчдын нэг нь Д. Дүгэрсүрэн юм.

Д.Дүгэрсүрэн 2009 онд Бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ)-ийн ахлагчаар сонгогдсон. Түүний удирдлага дор БАХ-ийн гишүүн малчид

бэлчээр ашиглалтын төлөвлөлтийг эхлүүлээд зогсохгүй даац хэтэрснээс үүдэн доройтоод байсан 20,000 га бэлчээрийг нөхөн сэргээх үүднээс таван жилийн хугацаагаар чөлөөлөн, бэлчээрийн менежментийг сайжруулж ирсэн. Тэрээр орон нутгийн удирдлагуудтай сумын бэлчээр болон хадлангийн талбайг ашиглах журмыг хэлэлцэж, малчдын бэлчээр ашиглах эрхийг баталгаажуулж, хадлангийн ургацыг сайжруулж, өвлийн тэжээлийн бэлтгэлийг хангах үүднээс хадлангийн талбай хаших зэрэг үйл ажиллагааг хамтарч санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Энэ нь малчдын хувьд орон нутгийн хөгжлийн сангаас авсан анхны санхүүжилт байсан юм.

2012 онд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд гурван малчин сонгогдсоны нэг нь БАХ-ийн малчдын дэмжлэгээр гарч ирсэн Д.Дүгэрсүрэн байв. Тэр үеэс хойш нийгэмд тустай, малчдад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхүйц хэд хэдэн төсөл хэрэгжүүлсэн нь орон нутгийн бусад удирдлагад үлгэр жишээ болов.

Тэрбээр уулаас эх аван урсдаг түргэн урсгалтай голыг гатлах гүүрийг малчдын оролцоотой барьсан нь хаврын бэлчээр лүү нүүх замыг нь саадгүй болгов. Уг голыг хаврын цагт гатлахад малчид болон малд ихээхэн бэрхшээлтэй байсан цаг саяхан. Тэрээр сумын удирдлагуудад гүүр барих хүсэлт хэд хэдэн удаа гаргасны эцэст сумын засаг дарга нь орон нутгийн хөгжлийн сангаас гурван сая төгрөгийг гүүр барихад зориулж баталсан. Малчид өөрсдөөсөө 1.5 сая төгрөгийг гүүр барихад нэмэрлэсэн. Үүнд орон нутгийн иргэд ихэд урамшиж, бусад хөгжлийн төслөө хэрэгжүүлэхэд орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжилт хүсэх болсноор дахин хоёр гүүрийг хамтын санхүүжилтээр барихад хүргэв. “Харин одоо мөрөөдөлдөө үнэнч хүнд хаалга үргэлж нээлттэй байдаг гэдэгт итгэдэг болсон. Миний хийсэн үйл бусад залуу малчинд ч үлгэр дуурайлал болж байгаа гэдэгт би итгэж байгаа. Нутгийнхаа хөгжилд хувь нэмэр оруулах мөрөөдлийнхөө би дөнгөж талыг нь л биелүүлээд байна” гэж Дүгэрсүрэн ярьсан юм.



Мэргэжлийн боловсрол,  
сургалт (МБС)



# Хөтөлбөрийн онцлох үр дүн

## **Залуучуудын хөгжлийг дэмжих нь**

2017 оны тавдугаар сард УИХ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг баталж залуучуудын хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчныг бүрдүүллээ. Ийнхүү ШХА-аас санхүүжүүлсэн төслүүдийн нөлөөлөл, үзүүлсэн дэмжлэгийн үр дүнд залуучуудын асуудал үндэсний хэмжээний бодлогод илүү өргөн хүрээтэйгээр тусгагдлаа. НҮБ-ын Хүн амын сан, ШХА-ийн хамтарсан санхүүжилтээр хэрэгжсэн Залуучуудын хөгжлийн төслийн (ЗХТ) хүрээнд дээрх хуулийг боловсруулан батлуулах ажлыг дэмжсэн нөлөөллийн үйл ажиллагаанд 60,000 гаруй залуучууд оролцжээ.



МБС-ийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж байна.  
© ШХА / ГОУХАН

ЗХТ нь 2018 оны зургадугаар сард дуусах бөгөөд төсөл дуусах хүртэлх хугацаанд холбогдох төрийн байгууллагад төслийн үйл ажиллагааг шилжүүлэх, тэдгээрийг албан ёсны тогтолцоонд бүрэн суулгахад чиглэн ажиллана. ЗХТ-ийн амжилтаас дурдахад амьдрах ухааны боловсролыг ерөнхий боловсролын бүх сургуулийн 6-9 дүгээр ангийн сургалтын хөтөлбөрт тусгуулснаар үүнд 2016-2017 оны хичээлийн жилд нийт 114,000 гаруй сурагчид хамрагдаж чадсан байна. Түүнчлэн төслийн дэмжлэгтэйгээр байгуулсан Амьдрах ухааны боловсролыг дэмжих 32 танхим, Залуучуудын хөгжлийн 16 төвөөр нийт 41,870 (тэдний 60 хувь нь эмэгтэйчүүд) залуучуудад хүрч үйлчилжээ. Нийт 153,780 гаруй залуучууд жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр төслөөс зохион байгуулсан кампанит ажил, арга хэмжээ, форумд оролцсон байна.

## **Залуучуудын хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх нь**

ШХА-ийн Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслөөс (ЗХЭДТ) залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үндэсний бодлогод зөвлөмж хүргүүлж, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийг боловсруулсаны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас тус хөтөлбөрийг баталж санхүүжүүлтийг хуваарилсан байна. Төслийн хүрээнд “Гарааны бизнесийг дэмжих загвар” боловсруулж төслийн хэрэгжүүлэгч зорилтот найман аймаг хоёр дүүрэгт туршин хэрэгжүүллээ. Загварын дагуу залуучуудын гарааны бизнест дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд нийт 626 (үүнээс эмэгтэйчүүд 349), залуучуудыг оролцож, шалгарсан 15 багт нийт 156 сая төгрөгийн буцалтгүй тусламж олголоо.

ЗХЭДТ нь үндэсний оролцогч талууд болон хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн байгууллагуудтай хамтран Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загварыг боловсруулж одоогоор гурван аймаг, нэг дүүрэгт туршилтын журмаар ажиллуулж байна. Төслийн хүрээнд үйлчлүүлэгч төвтэй, ажил олгогч болон ажил хайгч аль алиных нь хэрэгцээг хангахад чиглэсэн үйлчилгээ үзүүлдэг, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн уялдааг хангах зорилго бүхий эдгээр төвүүдийн үйл ажиллагааг туршихад хөдөлмөрийн албадын нийт 263 ажилтанд (үүнээс 53 хувь эмэгтэйчүүд) чадавх бэхжүүлэх сургалт зохион байгууллаа.

Мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх (МУЧХ) төслийн хүрээнд хувийн хэвшлийн төлөөлөл сургалтын хөтөлбөр шинэчлэн боловсруулах, суралцагсдын төгсөлтийн шалгалтанд оролцох, өөрийн аж ахуйн нэгж (ААН) компанидаа үйлдвэрлэлийн дадлагажуулагч багш нарыг бэлтгэх, сургалтын байгууллагатай хамтран оюутан суралцагсдын дадлагын ажлыг зохион байгуулах, нийгмийн түншлэлтэй холбоотой дүрэм журмыг боловсруулах ажилд идэвхтэй оролцож эхэлсэн.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ААН компанийн төлөөллөөс бүрдсэн мэргэжлийн зөвлөлүүд төслөөс дэмжиж буй мэргэжлийн чиглэлээр 12 МБС байгууллагууд дээр үйл ажиллагаа явуулж




байна. Үйлдвэрлэлийн дадлагажуулагч багшийн сургалтанд 100 хүн (33 нь эмэгтэй) оролцсоноос 88 нь дадлагажуулагч багшийг мэргэшүүлэх сургагч багшийн гэрчилгээ авсан. Эдгээр сургагч багш нарын 60 орчим хувь нь хувийн хэвшлийн төлөөлөл байна.

Техникийн мэргэжлээр суралцаж буй 27 эмэгтэй суралцагчдад төслийн хүрээнд тэтгэлэг олгосон. ЕБС-ийн сурагчдад техникийн мэргэжлийг сурталчлан таниулах үүднээс “Охид”, “Хөвгүүд”-ийн өдөрлөгийг тогтмол зохион байгуулж байна.

Хоёр жил тутам зохион байгуулагддаг Дэлхийн ур чадвар тэмцээн өнгөрсөн жилийн аравдугаар сард Абу Даби хотод болсон бөгөөд энэхүү тэмцээнд Монгол улс зургаан төрлөөр оролцсон юм. Зургаан оролцогчийн дөрөв нь төслийн түнш сургуулиудын суралцагч байсан.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэргэжилтэн бэлтгэх мэргэжлийн магистрын сургалтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорын яам (БСШУСЯ)-ны дэмжлэгтэйгээр Монгол Улсын Их сургуульд амжилттай эхлүүлсэн. Энэхүү салбар дундын магистрын сургалтанд 52 элсэгч бүртгүүлсэн бөгөөд элсэлтийн шалгалтанд тэнцсэн 33 оюутнаас одоогийн байдлаар 26 (үүнээс 37.5 хувь нь эрэгтэй) нь суралцаж байна.

Швейцарт төвтэй Мэргэжлийн бизнесийн сүлжээ (МБС) ТББ-ын 2012 оноос хойш хэрэгжүүлсэн Жижиг, дунд үйлдвэрийг (ЖДҮ) хөгжүүлэх төсөл гол зорилтууддаа хүрч, 2017 оны хоёрдугаар сараар ШХА-аас үзүүлж байсан дэмжлэг дуусгавар болов. Төсөлд хамрагдсан ЖДҮ нь маркетинг, бизнес, санхүүгийн менежментийн ур чадвараа сайжруулж, жилийн эргэлтийн хөрөнгөө 15 хүртэл хувиар, жилийн борлуулалтын хэмжээгээ 10-15 хувиар нэмэгдүүлжээ. Компаниудын 10 гаруй хувь нь гадаадад бүтээгдэхүүнээ (гол төлөв тэмээний ноос, сарлагийн хөөврөөр үйлдвэрлэлсэн бүтээгдэхүүн) экспортолдог болжээ. Нийт 102 ЖДҮ эрхлэгчид төслөөс ашиг хүртэж, 1165 ажлын байрыг дэмжсэн ба сонгогдсон ЖДҮ-ийн нийт ажилчдын 65хувь нь эмэгтэйчүүд байна. Эдүгээ МБС нь ШХА-ийн оролцоо, дэмжлэггүйгээр төслийг бие даан үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.




**Тогтвортой хөгжлийн боловсролыг ерөнхий  
боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх нь**

Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ) төсөл нь ТХБ-ын үзэл баримтлалыг Монголын ерөнхий боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх зорилгоо бататган ажиллав. Төслийн дэмжлэгтэйгээр багш бэлтгэх сургалтын ТХБ-ын нэгдсэн аргачлал бүхий хөтөлбөрийг боловсруулж, Боловсролын Их Сургуулийн шинжлэх ухааны зөвлөлөөр батлууллаа. Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран ажиллаж, 2017 онд багшаар ажиллаж байгаа 17,000 хүнд сургалт явуулжээ.

ТХБ төслийн 2016 онд хийсэн ерөнхий боловсролын сургуулийн жендэрийн дүн шинжилгээнд үндэслэн БСШУСЯ нь

боловсролын салбарын жендэрийн бодлогыг эцэслэн баталлаа. Төслөөс яамны ажилтнуудад техникийн тусламж, жендэрийн тухай сургалтуудыг явуулав.

Орон нутгийн түвшинд Улаанбаатар хот (40 сургууль), Архангай (3 сургууль), Сэлэнгэ (8 сургууль) аймгуудад сургуулийн ТХБ санаачлагууд, сургуульд түшиглэсэн орон нутгийн хөгжлийн санаачлагууд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Мөн, Баянхонгор, Хөвсгөл, Сэлэнгэ аймгуудын ногоон хөгжлийн баримт бичгийг боловсруулахад ажлын хэсгийн гишүүдийн чадавх бэхжүүлэх, зөвлөгөө өгөх замаар дэмжлэг үзүүлэв.



Төрийн захиргааны шинэтгэл,  
орон нутгийн засаглал,  
иргэдийн оролцоо

# Хөтөлбөрийн онцлох үр дүн

## **Орон нутгийн засаглалыг сайжруулж, иргэний нийгмийг бэхжүүлэх нь**

ШХА нь 2017 онд Монгол Улсад орон нутгийн засаглалыг сайжруулах талаар үзүүлж буй дэмжлэгээ улам бэхжүүллээ.

Тогтвортой амьжиргаа-3 төслийн дэмжлэгтэйгээр боловсруулсан Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-ийн хуваарилалтын журмыг Засгийн газар 2017 онд шинэчлэн баталлаа. Энэхүү журмаар ОНХС-ийн хуваарилалтын итгэлцүүр тус бүрийг тухайн орон нутгийн хүн амын тоонд харьцуулж тооцохоор томьёонд өөрчлөлт оруулснаар ОНХС-ийн хуваарилалтын тэгш байдлыг хангах нөхцөл бүрдлээ. Түүнчлэн уг төслийн хүрээнд нийт 330 суманд жилийн гүйцэтгэлийн үнэлгээ хийж, гүйцэтгэлд суурилсан урамшууллыг 154 суманд олгохоор боллоо.

Төсвийн тухай хуульд төр захиргааны байгууллагуудын чиг үүрэгт шинжилгээ хийж, чиг үүргийн дахин хуваарилалт хийж байхаар тусгав. ШХА-ийн Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төсөл Засгийн газарт чиг

иргэдэд ойртуулж, сайжруулахад чиглэж буй бөгөөд хоёр салбарыг сонгон хэрэгжүүлж эхлээд байна.

Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн (МУНЭХБТ) дэмжлэгтэй хэрэгжүүлсэн нийгмийн эгэх хариуцлагын чухал арга хэрэгслүүдээс үндэсний түвшинд албан ёсоор баталсан. Орон нутагт иргэний нийгмийн байгууллагын эмэгтэй төлөөлөгчдийн идэвхитэй оролцоотой хэрэгжсэн нийгмийн эгэх хариуцлагын хэд хэдэн санаачлагын үр дүнд эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж сайжран, иргэдийн сэтгэл ханамж дээшилж, улмаар үр шимийг нь нийт 138,000 хүн (үүнээс 53 хувь эмэгтэйчүүд), ялангуяа зорилтот 10 аймгийн эмзэг бүлгийн хүмүүс хүртэв. Тухайлбал, Хөвсгөл аймгийн Мөрөн суман дахь 7000 хүртэлх тооны түр оршин суугчид (50 хувь нь эмэгтэйчүүд, нийт хүн амын 17 хувь) өрхийн эмнэлэгт эрүүл мэндийн үндсэн үйлчилгээг авах боломжтой болсон.

Салбарын болон орон нутгийн бодлогын үнэлгээ, төлөвлөлтийн үйл явцад иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг оруулах шаардлага, удирдамжийг Монгол Улсын Засгийн газраас хяналт-шинжилгээ, үнэлгээний холбогдох дүрэм журамд оруулан шинэчлэн баталжээ. МУНЭХБТ-ийн дэмжлэгтэйгээр шинэчлэн боловсруулсан иргэдийн өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэх ёс зүйн хорооны удирдамжийг Эрүүл мэндийн яам баталлаа. МУНЭХБТ-ийн зорилтот арван аймгаас тав нь нийгмийн эгэх хариуцлага, холбогдох арга механизмын нэвтрүүлэх талаар орон нутгийн бодлого, дэд хөтөлбөрүүдийг баталж, эцэг эхчүүд сургуулийн төсөв, худалдан авалт, төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналтад оролцох болсноор сургуулийн засаглал сайжирлаа. Нийгмийн эгэх хариуцлагын чиглэлээр богино хугацааны сертификат олгох сургалтыг төслийн дэмжлэгтэй Удирдлагын академиас боловсруулан богино сургалтын хөтөлбөртөө тусгасан байна.

Хотын засаглалыг сайжруулах төслийн дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотын захиргаа иргэдэд үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох цахим хуудас нээснээр, шийдвэр гаргагчид



Сумын хэмжээнд тулгамдсан асуудлаа шийдвэрлэх сумын иргэд, удирдлагууд газрын зураглалын арга ашиглан үйл ажиллагаагаа хамтран төлөвлөж байгаа нь. Завхан аймгийн Их-Уул сум.  
© ШХА

үүргийн дахин хуваарилалт хийх аргачлалыг боловсруулан бусад салбарт хэрэгжүүлэхээс өмнө Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт туршлаа. Энэ аргачлал нь төрийн байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилган бүтээмжийг сайжруулах, төрийн үйлчилгээг



иргэдийн хэрэгцээ, шаардлагын талаар илүү сайн ойлголт, бодит мэдээлэлтэй болж, шийдвэр гаргахдаа ашигладаг болж байна. Мөн гэр хорооллын 87 хороонд ОНХС-аас

санхүүжсэн төсөл, тухайн хороонд амьдарч буй зорилтот бүлгүүдийн байршлыг харуулсан газрын зураглалуудыг боловсруулсан нь нийгмийн бүлэг бүрийн саналыг тусгасан, тоо баримтад суурилсан хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үйл явцыг дэмжихэд чиглэж байна.

2017 онд нийтийн зориулалттай барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийн гэрчилгээг үндэсний хэмжээнд боловсруулан баталснаар үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн ил тод байдлыг бий байна. Түүнчлэн барилгын улсын стандартуудыг нийтийн эзэмшлийн бүх шинэ барилга байгууламжид ашигладаг боллоо. Төсвийн хөрөнгө оруулалтыг сайжруулснаар эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлсэн батэслийн эхний шатанд нэвтрүүлсэн дулаан тусгаарлалтын технологийг Ховд аймагт шинээр баригдсан 49 орон сууцны 39 нь ашиглажээ.

Тус төслийн хүрээнд сургууль, дотуур байр, эмнэлэг, цэцэрлэг зэрэг нийтийн зориулалттай 16 байр байгууламжид дулаан техникийн засвар шинэчлэл хийсний үр дүнд баруун бүсийн алслагдсан сумдын 130,000 гаруй иргэдийн амьдрах, ажиллах нөхцөл сайжирчээ. Нийтийн зориулалттай барилга байгууламжид хийсэн засвар шинэчлэлийн нийгэм, эдийн засгийн үр ашгийг авч үзвэл хүүхдүүдийн өвчлөлийн улмаас сургууль, цэцэрлэг завсардах явдал буурч, эцэг эхчүүдийн эм, эмчилгээний зардал 65 хувиар багассан бөгөөд нүүрс хэрэглэснээс ялгарч байсан хорт CO2 хийн хэмжээ 60 гаруй хувиар буурчээ.

Төлөөллийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх төсөл нутгийн удирдлагын эрх зүйн хүрээг тодорхойлдог гол хуулийн хэрэгжилтэд цогц үнэлгээ хийснээр нутгийн удирдлагын эрх зүйн орчныг сайжруулахад хувь нэмэр оруулж байна.

## ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА, ИНБ-ЫН ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

### Орон нутгийн удирдлагын чадавх бэхжүүлэх чиглэлээр

ИТХ-ийн төлөөлөгчид суурь сургалтад хамрагдлаа.

**7377** → **1942** ЭМЭГТЭЙ

Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан үндэсний түвшиний 10 аймгийн албан хаагч сургалтад хамрагдлаа.

**230** → **1700** ЭМЭГТЭЙ

Нийслэлийн нийт **152** хорооны

**136** Засаг дарга → **77** ЭМЭГТЭЙ

**190** зохион байгуулагч → **116** ЭМЭГТЭЙ

**1400** хэсгийн ахлагч → **1297** ЭМЭГТЭЙ

**131** нийгмийн ажилтан → **116** ЭМЭГТЭЙ

**1026** амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүд → **844** ЭМЭГТЭЙ

чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдлаа.

### ИНБ, иргэд, хэвлэл мэдээллийн чадавх бэхжүүлэх чиглэлээр

Нийгмийн эгэх хариуцлагын талаарх сургалтад нийт **93** ИНБ, **22,000** → **45%** ЭМЭГТЭЙ төрийн албан хаагч хамрагдлаа.

**95** сэтгүүлчдэд нийтлэлдээ жендерт суурилсан хүчирхийллийн асуудлыг хэрхэн тусгах тухай сургалт зохион байгуулсан.

Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой

- 15** видео,
- 28** сонин нийтлэл, ярилцлага,
- 15** комик ном,
- 60** минутын баримтат кино,
- 9** радио нэвтрүүлэг бэлтгэжээ.

Хэвлэл мэдээллийн 10 төрлийн бүтээгдэхүүн хөгжүүлж, **100,000** гаруй хүний нийгмийн эгэх хариуцлагын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлсэн.

Жендерт суурилсан хүчирхийллийн тухай мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх **16** өдрийн кампанит ажлаар нийт **25,000** хүнд хүргэлээ.

ШХА©

### **Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх олон талт хамтын ажиллагаа**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны хоёрдугаар сарын 1-нд батлагдаж, Засгийн газар 2017-2021 оны Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр баталсан зэрэг нь олон улсын болон үндэсний байгууллагуудын өргөн хүрээний нөлөөллийн ажлын үр дүн юм. ШХА-ийн санхүүжүүлтээр хэрэгжиж байгаа Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл (ЖСХТТ) нь энэхүү нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр ажиллах үндэсний чадавхийг бий болгоход дэмжлэг үзүүлж байна. Дээрх үндэсний хөтөлбөрт жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг авах хариу арга хэмжээ, сумын жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтүүдийг оруулсан ба хөтөлбөрт охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн. Хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэх 15 журмыг оруулсан ба олон салбарын үйл ажиллагааны зохицуулалт, хариу арга хэмжээг сайжруулж байна.

ЖСХТТ-ийн техникийн ба санхүүгийн дэмжлэгтэйгээр Үндэсний Статистикийн Газар анхны жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ)-ийн судалгааг явуулж, судалгааны урьдчилсан дүн ЖСХ, ялангуяа гэр бүлийн хүчирхийллийн эсрэг цогц арга барилаар тэмцэх шаардлага өндөр байгааг харууллаа. ЖСХ-ийн эцсийн тайлан 2018 оны эхээр гарах бөгөөд нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргахад ашиглагдана. Судалгааны эхний үр дүнд тулгуурлан ЖСХ хамгийн өндөр байгаа 10 газар нэг цонхны үйлчилгээний төв шинээр байгуулах болов. Цагдаагийн ерөнхий газарт улсын хэмжээнд бүх нэг цонхны үйлчилгээний цэгүүд, хоргодох байруудыг холбосон нэгдсэн мэдээллийн санг шинээр байгуулахад дэмжиж ажиллав.

2017 оны байдлаар одоо ажиллаж байгаа нэг цонхны үйлчилгээний төвөөр нийт 2,077 хохирогч үйлчлүүлсэн ба 207 хэргийн мөрөөр хүчирхийллийн хохирогч нарт зориулсан эмнэлэг, сэтгэл зүй, эрх зүй, зуучлал, нийгмийн үйлчилгээ үзүүлдэг олон салбарын мэргэжилтнүүдийг хамарсан багууд ажиллажээ.



Үндэсний статистикийн газар анх удаа ЖСХ-ийн судалгааг явуулснаар олон эмэгтэйчүүдийн хэнд ч хэлж байгаагүй сэтгэл эмзэглүүлсэн түүх, тоо баримтыг цуглууллаа.  
© ШХА / НҮБХАС



Тогтвортой бичил уурхай  
төсөл



# Хөтөлбөрийн онцлох үр дүн

## Бичил уурхайг албажуулах нь

ШХА-аас Монголын бичил уурхайн салбарын албажилтыг дэмжсэний үр дүнд бичил уурхайтай холбоотой асуудлуудыг бодлогын чухал баримт бичгүүдэд 2017 онд тусгуулсан байна. Бичил уурхайчдын ажлын нөхцлийг сайжруулах, төрийн байгууллагуудын харилцан уялдааг дээшлүүлэхэд ач холбогдол бүхий Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох

журмыг Засгийн газрын 151-р тогтоолоор шинэчлэн баталлаа. Шинэ бодлого, үйл ажиллагааны журмаар бичил уурхайн салбарыг албажуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах, тус салбарт хүүхдийн хөдөлмөрийг устгах, байгаль орчныг нөхөн сэргээх зэрэг асуудлыг цогцоор нь зохицуулсан байна.



Бичил уурхайг албажуулснаар бичил уурхайчид хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг нэн тэргүүнд тавих болов. Баянхонгор аймгийн Баян-Овоо сум дахь бичил уурхайчдын ХАМОДХ нөхөрлөл. © ШХА

Бичил уурхайн техникийн стандартыг сайжруулах, бичил уурхайг алтны нийлүүлэлтийн сүлжээнд оруулах эрхзүйн хүрээг бий болгох замаар бичил уурхайн алтны олборлолтыг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газар 2017-2020 оны "Алт-II" хөтөлбөрийг батлав. 2017-2020 оны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тавдугаар хөтөлбөрт бичил уурхайн хөдөлмөрийн

ажуулгүй байдал, хөдөлмөрийн нөхцөл байдлын тухай анх удаа албан ёсоор тусгажээ.

2013-2016 онд ШХА-ийн хэрэгжүүлсэн Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх төслийн нэг гол үр дүн болох Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг БОАЖЯ, УУХҮЯ-ны сайд нарын хамтарсан тушаалаар 2017 онд албан ёсоор баталжээ.





# 2018 оны ХЭТИЙН ТӨЛӨВ

2018-2021 онд хэрэгжүүлэх Швейцарын Хамтын ажиллагааны шинэ стратеги нь Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал; Суурь боловсрол ба мэргэжлийн сургалт (СБМС); Засаглал гэсэн гурван үндсэн чиглэлээр үргэлжилнэ. Хөгжлийн нөхцөл байдал, эдийн засгийн чадавх өөрчлөгдөж байгаагаас хамааран энэхүү стратеги нь Монгол дахь ШХА-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр төсөлд орох цаашдын өөрчлөлтийг тодорхойлох юм. 2018-2021 онд хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал гэсэн үндсэн чиглэл хөдөө орон нутагт уур амьсгалын өөрчлөлтийн асуудлуудыг шийдвэрлэхэд түлхүү чиглэх болно. СБМС-ын үндсэн чиглэлийн хамрах хүрээг үе шаттайгаар багасгана. Ил тод, уян хатан, хариуцлагатай төсвийн байгууллагууд тус улсын нөөц баялгийн үр шимийг тэгш хуваарилахад чухал урьдчилсан нөхцөл болдог учраас засаглалын үндсэн чиглэлийн ач холбогдол цаашид улам өснө. ШХА нь хөдөөнөөс хотын захын гэр хороололд гол төлөв шилжин суурьшиж буй шилжилт хөдөлгөөн дагасан хотжилтын асуудалд илүү анхаарал хандуулна.

2018 онд Төсвийн хөрөнгө оруулалтыг сайжруулснаар эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх нь төслийн хоёрдугаар үе шатанд өмнө нь амжилттай хэрэгжүүлсэн өмнөх шатны сайн туршлагыг Улаанбаатар хотын сонгогдсон гэр хорооллуудад нэвтрүүлнэ. Ногоон алт төслийн үйл ажиллагааг 21 аймгийг бүхэлд нь хамруулахаар хүрээг тэлж буйтай холбоотойгоор нэмэлт санхүүжилт олгоно. ТХБ-ын төслийн хугацааг нэмэлт санхүүжилтгүйгээр нэг жилээр сунгана.

"Хэтийн төлөв 2020" төсөл нь шинэ төслүүдээр дамжуулан хөтөлбөрийн стратегийн чиглэлийг шинэчлэхэд хувь нэмэр оруулна.

- НҮБ-ын Хүүхдийн Сан (НҮБХС), Оксфордын Бодлого удирдлагын төвийн хийсэн "Хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөөллийн нотолгоог сайжруулах" судалгаагаар 2018 онд шийдвэрлэхээр ажиллах шаардлагатай зарим асуудлыг тодорхойлж өгсөн. Оролцогч талуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд энэхүү судалгааны үр дүнг тараах стратеги гаргах хэрэгтэй байна. Судалгааны

зөвлөмжүүдийг төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхэд техникийн тусламж үзүүлэх шаардлагатай. НҮБХС-тай амжилттай хамтран ажилласан туршлага дээр үндэслэн НҮБХС-ийн тэргүүлж байгаа НҮБ-ын Агаарын бохирдолтой тэмцэх хөтөлбөрт оруулж болох хувь нэмрийн талаар яриа хэлэлцээ явуулна.

- 2017 оны хоёрдугаар хагаст Хог хаягдлын менежментийн засаглалын тухай судалгааг хийсэн. Үүгээр ШХА-ийн хувьд цаашид оролцож болох хэд хэдэн чухал асуудлыг тодорхойлсон ба засаглалын үндсэн чиглэлээр шинэ хөтөлбөр эхлүүлнэ. Энэ талаар Монголын ба Швейцарын хувийн хэвшлийнхэнтэй хамтран ажиллах боломжийг судалж байна.
- Олон Улсын Шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран дотоодын шилжилт хөдөлгөөний үнэлгээг (шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх хүчин зүйлсийн дүн шинжилгээ, эмзэг байдлын үнэлгээ) хийснээр 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны сонирхолтой чиглэлийг гаргаж өгөх боломжтой юм.
- ШХА-аас БНХАУ-д хэрэгжүүлж буй Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт хөтөлбөртэй хамтын ажиллагаагаа бэхжүүлж, Хятад улсын туршлага, ялангуяа агаарын бохирдол, нүүрсхүчлийн ялгарал багатай хөгжлийн амжилттай арга барилыг Монгол улсад нэвтрүүлэх зорилготой ажиллана.
- Гурван талт хамтын ажиллагаагаар БНХАУ-ын Газар хөдлөлтийн удирдах газартай хамтран 2018 онд ШХА-ийн хүмүүнлэгийн тусламж, ОБЕГ-ын хотын нөхцөлд эрэн хайх-аврах чадавхыг бэхжүүлэх чиглэлээр ажиллана.

ШХА үндсэн чиглэлүүдээр зорилтот мэдээллийг Монгол Улсын Засгийн газарт хүргэх зорилгоор бодлогын яриа хэлэлцээг үргэлжлүүлэн явуулна. Мөн ядуурлын түвшин нэмэгдэж байгааг харгалзан цаашид ч жендэрийн тэгш байдлыг хангах, ядуурлыг бууруулахад анхаарч ажиллана. Түүнчлэн, Ногоон алт, малын эрүүл мэнд төсөл, ТБУТ, Нутгийн өөртөө удирдах байгууллагуудын чадавх бэхжүүлэх төсөл зэрэг ШХА-ийн томоохон төслүүдийг дуусгавар болгох, тогтвортой байдлыг хангахад анхаарч ажиллана.

# Товчилсон үгс

ААН	Аж ахуйн нэгж
БАГ	Бэлчээр ашиглалтын гэрээ
БАХ	Бэлчээр ашиглагчдын хэсэг
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорын яам
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ЗХТ	Залуучуудын хөгжлийн төсөл
ЗХЭДТ	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл
МАН	Монгол Ардын Нам
МБАНХ	Монголын Бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо
МБС	Мэргэжлийн бизнесийн сүлжээ
МУНЭХБТ	Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төсөл
МУЧХТ	Мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх төсөл
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХС	НҮБ-ын Хүүхдийн Сан
ОУВС	Олон улсын валютын сан
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СБАХ	Сумын бэлчээр ашиглагчдын холбоо
СБМС	Суурь боловсрол ба мэргэжлийн сургалт
ТБУТ	Тогтвортой бичил уурхай төсөл
ТХБ	Тогтвортой хөгжлийн боловсрол
УИХ	Улсын Их Хурал
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг